## ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ

***Газрын удирдлагын хэлтэс***

***2024.06.18***

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр тогтоолоор 2024 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр 3 байршилд 10.3 га газрыг Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар олгохоор Баянтал сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/85 дугаар захирамжийн дагуу газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар нийтэд мэдээлсэн байна.

Төсөл сонгон шалгаруулалт 2024 оны 06 дугаар сарын 27-ны зохион байгуулж ялагч тодорно.

***ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАЖ БУЙ ГАЗРУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ***

| Д/д | Эзэмшүүлэх газрын байршил | Газрын зориулалт | Газрын хэмжээ /$м^2$/ | Газар эзэмших хугацаа /жил/ | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Улсын тэмдэгтийн хураамж |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 16-р зөрлөгийн зүүн урд талд | Мал аж ахуйн үйлдвэрлэл | 50000 | 15 | 4092190 | 12500 |
| 2 | Цэргийн ангийн зүүн талд | Мал аж ахуйн үйлдвэрлэл | 50000 | 15 | 4106379 | 12500 |
| 4 | 16-р зөрлөгөөс зүүн урагш | Мал аж ахуйн үйлдвэрлэл | 3000 | 15 | 4110976 | 12500 |





Шивээговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр тогтоолоор 2024 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр 4 байршилд 20 га газрыг Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар олгохоор батлагдаж төсөл сонгон шалгаруулалтыг зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 14 өдөр Дугаар 04 Шивээговь сум

Сумын газар зохион байгуулалтын 2024 оны
тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр газар
тусгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 187 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, сумын ИТХ-ын ээлжит бус 31-р хуралдааны тооллогын комиссын 2024.06.14-ний өдрийн 06, 07 дугаар "Санал хураалтын дүнгийн тухай" тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын газар зохион байгуулалтын 2024 оны тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгах газрыг хавсралтаар батлагсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бүтэн жилээр тайлагнахыг сумын Засаг дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА А.ДЭЛГЭРЗАЯА

C:Documents|B-H| togtool.doc



Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар
сарын 14-ний өдрийн ээлжит бус 31 дугаар хуралдааны
04 дүгээр тогтоолын хавсралт

ШИВЭЭГОВЬ СУМЫН 2024 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ

10202005: МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ /МАЛЧДЫН ХОРШОО/

| № | Сум/Дүүрэг | Баг/Хороо | Төлөвлөлтийн нэгж талбар | Солбицол | Газрын нэр | Газрын зориулалт | Арга хэмжээний төрөл | Талбайн хэмжээ [m2] | Улирал III | Улирал IV | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шивээговь | 2-р баг | 4095419 | X=314532.62 Y=5105221.00<br>X=314782.62 Y=5105221.00<br>X=314782.62 Y=5105421.00<br>X=314532.62 Y=5105421.00<br>X=314532.62 Y=5105221.00 | Хөтлийн ухаан хойд талд | 1613: Эрчимжсэн мал аж ахуйн ферм | Төсөл сонгон шалгаруулалт | 50000 | + | | Засаг дарга, Газрын даамал |
| 2 | Шивээговь | 2-р баг | 4095420 | X=314782.62 Y=5105221.00<br>X=315032.62 Y=5105221.00<br>X=315032.62 Y=5105421.00<br>X=314782.62 Y=5105421.00<br>X=314782.62 Y=5105221.00 | Хөтлийн ухаан хойд талд | 1613: Эрчимжсэн мал аж ахуйн ферм | Төсөл сонгон шалгаруулалт | 50000 | + | | Засаг дарга, Газрын даамал |
| 3 | Шивээговь | 2-р баг | 4096866 | X=312854.00 Y=5107770.00<br>X=313104.00 Y=5107770.00<br>X=313104.00 Y=5107970.00<br>X=312854.00 Y=5107970.00<br>X=312854.00 Y=5107770.00 | Хогын цэгийн урд | 1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл | Төсөл сонгон шалгаруулалт | 50000 | + | | Засаг дарга, Газрын даамал |
| 4 | Шивээговь | 2-р баг | 4096867 | X=313104.00 Y=5107770.00<br>X=313354.00 Y=5107770.00<br>X=313354.00 Y=5107970.00<br>X=313104.00 Y=5107970.00<br>X=313104.00 Y=5107770.00 | Хогын цэгийн урд талд | 1602: Мал эмнэлгийн үйлчилгээний цэг | Төсөл сонгон шалгаруулалт | 50000 | + | | Засаг дарга, Газрын даамал |







***Барилга, хот байгуулалтын хэлтэс***

Говийн бүсийн "Барилгачдаа сонсъё" зөвлөгөөнийг Монголын Барилгачдын нэгдсэн холбоо, Дорноговь, Дундновь, Өмнөговь, Говьсүмбэр аймгийн барилгачдын холбоод хамтран 2024.06.03-ний өдөр Дорноговь аймагт зохион байгуулсан. Зөвлөгөөнд аймгийн Барилгачдын холбоо, орон нутгийн салбарын аж ахуйн нэгж байгууллагын инженер техникийн ажилчид, ГХБХБГ-ын нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

Уг зөвлөгөөнд барилга, барилгын материалын үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтэд баримталж буй бодлого, чанар, стандарт, хөгжлийн чиг хандлага сэдвээр мэдээлэл хийгдсэн.







2024 оны 06 дугаар сарын байдлаар дараах 3 объектод лабораторийн шинжилгээ болон материалын хэмжилт хийгдсэн байна.Үүнд:

- Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн гадна хашааны ажил
- Шивээговь сумын "Нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажил
- Сүмбэр сумын 5-р сургуулийн 320 хүүхдийн сургуулийн барилгын ажил









Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох баримт бичгийг хянаж, Urban.gov.mn кадастрын цахим систем болон цаасан хэлбэрээр олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сард барилга байгууламжийн ажил үргэлжлүүлэх сунгалт хийгдсэн **6** объект, шинээр ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон **4** объект байна.

2024 оны 6-р сарын байдлаар Улсын төсвийн 6 объектын 6,1 тэр бум төгрөг, Орон нутгийн төсвийн 10 объектын 934,7сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг тус тус хянаж баталгаажуулсан байна.

2024 оны 06 дугаар сарын байдлаар улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 13,6 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 барилга байгууламжийн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.Үүнд:

Боржигон чуулгын барилга



Ахмадын өргөөний барилга



5-р сургуулийн өргөтгөлийн барилга



Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга



Баянтал сумын 3,4км авто замын ажил



Цэвэрлэх байгууламжийн ажил



Тайлан нэгтгэсэн: Т.Урантогос